



UNDRR

**НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг
бууруулах газар(UNDRR)-аас
сургуулийн орчинд зохион байгуулах
аюулгүй байдлын сургалтын багш
нарт зориулсан гарын авлага
(бага ангийн сурагчдад чиглэгдсэн)**

UNDRR

танилцуулга

НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар(UNDRR) нь НҮБ-ын харьяа гамшигтай тэмцэх байгууллага хоорондын хамтын ажиллагаа, олон улсын гамшгийн эрсдэлийг бууруулах стратегиар дамжуулан гамшигт тэсвэртэй нийгмийг бий болгож, гамшгийг бууруулах арга хэмжээг нийгэм, эдийн засаг, хүмүүнлэгийн үйл ажиллагаатай уялдуулан үр дүнг нь дээшлүүлэх зорилгоор 1999 онд НҮБ-ын харьяа байгууллага болон үүсгэн байгуулагдсан. Мөн бүс нутгийн 10 салбар дотроос UNDRR Зүүн Хойд Азийн салбар оффис-Олон улсын сургалтын институт (UNDRR ONEA-GETI) нь Солонгос, Япон, Хятад, Хойд Солонгос, Монгол улсад гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх сүүрх баазыг үүсгэж, Зүүн Хойд Азийн бүсийн цаг агаарын өөрчлөлттэй тэмцэх хамтын ажиллагааны хүрээг бий болгож, цаашлаад дэлхийн том хотуудын хотжилттой холбоотой үүсэх гамшгийн эрсдэлийг бууруулах стратегиар ханган, төрийн албаны болон холбогдох байгууллагын ажилчдыг сургалтанд хамруулан, гамшгийн эрсдэлийг бууруулах болон цаг агаарын өөрчлөлттэй тэмцэх салбарын мэргэжилтэнг бэлтгэх зорилгоор БНСУ-ын Засаг захиргаа, Аюулгүй байдлын яам болон Инчеон хотын дэмжлэгээр 2010 онд байгуулагдсан.

Сургуулийн орчинд зохион байгуулах аюулгүй байдлын сургалт-Танилцуулга

Үүсэх болсон түүх

UNDRR Зүүн Хойд Азийн салбар оффис-Олон улсын сургалтын институт (UNDRR ONEA-GETI) UNDRR, БНСУ-ын Засаг захиргаа, Аюулгүй Байдлын Яам, Инчеон хот хамтран UNDRR байгууллагын хуримтлуулсан олон улсын гамшгийн мэдлэг мэдээллийн бааз, дүрс бичлэг зэргийг ашиглан Солонгосын нөхцөл байдалд нийцүүлэн бэлтгэсэн сурагчдад зориулсан гамшгаас урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын сургалт юм.

Сургалтын зорилго



Онцлог

- Урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт

Гамшиг үүсэхээс өмнө сурагчид юу мэдэж бас юу хийж чадах болон сурагчдын хийх ёстой зүйлсийг урьдчилж зааж сургахад чиглэсэн агуулгаас бүрдсэн сургалт юм.

- Хэлэлцүүлэг, оролцоонд төвлөрсөн сургалт

“Эрсдэлийн арал тоглоом” (Riskland game), Hazard bingo, видео гэх мэт нэмэлт материалуудыг ашиглан сурагчдад гамшгийн аюулыг хэрхэн бууруулж болох талаарх мэдлэгийг ойлгомжтойгоор өгч, сурагчид өөрсдөө биечлэн оролцож, хэлэлцүүлэг явуулах аргаар сургалт явагдана.

Сургуулийн орчинд зохион байгуулах аюулгүй байдлын сургалтын бүтэц

Хичээлийн дараалал

Хугацаа	Материал	Үндсэн агуулга	Хуудас
20мин	PPT материал	Гамшгийн эрсдэлийг бууруулах тухай ойлголт	4
10мин	Tilly Smith бичлэг	Гамшгаас сэргийлэх аюулгүй байдлын сургалтын ач холбогдол	10
30мин	Riskland game	Тоглоомоор дамжуулан гамшгийн эрсдэлийг бууруулах болон урьдчилан сэргийлэх талаар суралцах	11
30мин	Hazard bingo game	Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар сурсан зүйлээ бататгах	13



Гамшгийн эрсдэлийг бүүрүүлэх үзэл баримтлалыг ойлгох

Сургалтын зорилго

Гамшиг болон эрсдэлийн хүчин зүйлийн ялгааг ялгаж чаддаг, бидний эргэн тойронд эрсдэлийн хүчин зүйл байгаа эсэхийг мэддэг төдийгүй эмзэг байдал яагаад бий болдог, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бүүрүүлснаар хохирлыг багасгаж болох талаар суралцана.

Багш болон сургалт

Гол агуулга

Хар салхи, газар хөдлөлт, үер гэх мэт эрсдэлт хүчин зүйлүүд нь байгалийн үзэгдэл төдий мэт харагдавч хэрхэн урьдчилан сэргийлж, бэлтгэлтэй байж, эрсдэлийг бүүрүүлж чадахаас хамааран гамшгийн хэмжээнд хүрж ч болно, зүгээр байгалийн үзэгдэл болон өнгөрч ч болдгийг чухалчилна. (эрсдэлийн хүчин зүйл ≠ гамшиг)



Багшийн сургалтын хэрэглэгдэхүүн (бэлтгэх зүйл) PPT материал

Гол агуулга

Эрсдэлийн хүчин зүйл



●● Ойлголт

Хэдийгээр байгалийн үзэгдэл ч гэсэн хүмүүсийн хувьд урьдчилсан бэлэн байдлыг хангаагүйн улмаас амь нас, эд хөрөнгө, байгаль орчинд аюул авчирч болохыг хэлнэ.

●● Эрсдэлийн хүчин зүйлсийн ангилал

- Байгалийн хүчин зүйлс: газар хөдлөлт, хар салхи, галт уулын дэлбэрэлт, үер гэх мэт
- Хүнээс үүсэлтэй хүчин зүйлс: байгаль орчны бохирдол, үйлдвэрийн осол гэх мэт



Сонгох хөтөлбөр 2

Q. Дасгал ажил 1

Бидний эргэн тойронд байгаа эрсдэлийн хүчин зүйлүүд дотроос хүмүүсийн бий болгосон хүчин зүйлс болон байгалиас үүсэлтэй хүчин зүйлсийг хооронд нь ялгах хөтөлбөр

Зураг болон үг (тайлбар)-ыг холбоод, тэр нь байгалийн хүчин зүйлс үү, хүмүүсээс үүдэлтэй хүчин зүйлс үү гэдгийг хэлээрэй.

<p>Цунами Ерөнхийдөө далай тэнгэсийн гүнд галт уулын дэлбэрэлтийн улмаас үүссэн асар том давалгааг хэлнэ. Далайн эргийг нягтран хүмүүсийн амьдрал байгаа газрыг сүйтгэх хэмжээний хүчтэй.</p>	<p>Газар хөдлөлт Дэлхийн гадаргуу болон тивүүдийг бүрдүүлдэг газрын давхаргын нөхцөлөөс болж газар чинирч, хадлах явдал юм.</p>	<p>Үер Гол мөрний үс эргэ даваг бусад газар руу халин урсахыг хэлнэ.</p>	<p>Хөрсний нуралт Их хэмжээний шороо эсвэл хөрс гянт доош урсах үзэгдлийг хэлнэ.</p>
<p>Халдварт өвчин Халдварлах шинжтэй өвчин нь маш хурдацтай олон хүнд тархдаг.</p>	<p>Ган Удалн жугашааны турш хур бороо ороогүйн улмаас усны хэт дутгалд орох үзэгдлийг хэлнэ. Мөн хүний буруутай үйлдлээс болж ган үүсч болно. Жишээ нь, голын урсгалын дээд хэсэг далайн баривал голын доод хэсэгт амьдрах байгаа тогсоны хүмүүс ганд орж болзошгүй.</p>	<p>Зуд Цас гянт их хэмжээгээр орж хунгарлаж эхэлнэ.</p>	<p>Галт уулын дэлбэрэлт Малца дэлхийн гадаргад хурц үед лава болон галт уулын үнс үүсэхийг хэлнэ.</p>
<p>Хар салхи Онцгой нөхцөл байдал үүсдэг халуун орны далайн хүчтэй шуурга юм.</p>	<p>Өвчин дамжуулагч организм Хүн, газар тарвалан, амьтад зэрэг ургамал, амьтан, шашныг үлчилж тархуулах хэлнэ.</p>	<p>Технологийн эрсдэлт хүчин зүйлс Техник технологийн өндөр хөгжил, үйлдвэрлэлтээс үүдэлтэй асуулыг хэлнэ. Жишээ нь, үйлдвэрийн дэлбэрэх осол, химийн нэгдэл борлох болон цахилгаан цацрагийн тархалт гэх мэт.</p>	<p>Ойн түймэр Ой болон ууланд гарсан гал хяналтаас гарч, хурдацтай түймэр болон дэгдэгийг хэлнэ.</p>

Q. Дасгал ажил 2

Сурагчид өөрсдийн эргэн тойронд ямар ямар эрсдэлийн хүчин зүйлс байгааг хайж олох оюун ухааны хөтөлбөр.

연습문제 2

Бидний эргэн тойронд ямар эрсдэлийн хүчин зүйлүүд гамшгийн хэмжээнд очдог вэ?

Эмзэг байдал



●● Ойлголт

Эрсдэлийн хүчин зүйлсийн улмаас хохиролд амархан өртөхийг хэлнэ.

●● Эмзэг байдал бий болдог шалтгаан?

Цаг агаарын өөрчлөлт, дэлхийн дулаарлаас үүдэлтэй далайн усны түвшин дээшилснээр далайн эрэг орчмоор амьдардаг хүмүүст далайгаас үүдэлтэй хохирол учрах тул эмзэг байдлыг нэмэгдүүлж болно.

Ядуурал Ядуу хүмүүс аюулгүй газарт суурьшиж чадахгүйгээс эрсдэл ихтэй газарт амьдрах тохиолдол их байдаг тул эмзэг байдлыг ихэсгэж болно.

Боловсролын тэнцвэргүй байдал Сургалт авч чадаагүй хүмүүс нь сургалт авсан хүмүүсээс гамшгийн талаарх мэдээлэл дутмаг байдаг тул эмзэг байдлыг ихэсгэж болно.

Гамшгийн даатгалд хамрагдаж чадаагүй хүмүүс нь даатгалд хамрагдсан хүмүүстэй харьцуулахад гамшгийн хохирлын нөхөн төлбөр авч чаддаггүй тул эмзэг байдлыг ихэсгэж болно.

Амьдарч байгаа газрынхаа хэл болон орчны мэдээллийн дутмаг байдал Амьдарч байгаа газрынхаа хэлийг ойлгохгүй бол аюулын сэрэмжлүүлгийн дохиол болон мессежийг ойлгож чадахгүй байх, мөн аюул тохиолдсон үед зохих арга хэмжээг авч чадахгүй байдлын улмаас эмзэг байдлыг ихэсгэж болно.

Аюулын эрсдэлтэй бүсэд амьдарч байгаа хүмүүс ойр орчин тойронд ямар эрсдэлийн хүчин зүйлс байгааг мэдэж байх хэрэгтэй. Зурган дээрээс харвал хүмүүс хад чулууг харахгүй байгаагаас эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. (Хүмүүс хад руу харж байна гэдэг нь эргэн тойрны эрсдэлийн хүчин зүйлсийг урьдчилан мэдэж, цаг хугацааны хувьд бэлтгэл хийх боломжтой гэсэн үг.)

Үерийн аюултайг сануулсан яаралтай мэссэж авсан гэж бодъё. Бидний эргэн тойронд хэн хамгийн ихээр аюултай байдалд байна вэ? Үерийн аюулд өртөж болох хүмүүсийг хамгаалахын тулд юу хийж болох вэ?



Газрын зураг дээр анхаарах зүйлс




Сонгох хөтөлбөр

Q. Дасгал ажил 3

Эрсдэлд илүү өртөж болох хүнийг олох.

Жишээ нь: өндөр настан, жирэмсэн эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гадаад иргэд, бага насны хүүхдүүд гэх мэт

Гамшиг



●● Ойлголт

Эрсдэлийн хүчин зүйлсийн улмаас амь нас, эд хөрөнгө, байгаль орчин, амьжиргаанд нь хохирол учрахыг хэлнэ.

- Амь нас, эд хөрөнгө, байгаль орчин, амьжиргаанд нь хохирол учраагүй бол гамшиг гэж үзэхгүй.



Газрын зураг дээр анхаарах зүйлс

Зурган дээрээс харахад аав ээж нь хохирол амссан (нас барах юмуу гэмтсэн) тул хүүхэд нь амжиргааны баталгаагаа алдсан хохирол учраад байна.

※ Тэгэхээр бидний хэрэглэж заншсан “байгалийн гамшиг” гэсэн нэршил нь оновчтой биш харин “байгалийн эрсдэлийн хүчин зүйлс” гэж хэлэх нь илүү оновчтой юм.

Эрсдэлийн хүчин зүйлс болон гамшгийн ялгаа (Жишээ)



Газар хөдлөлт гэсэн яг л адилхан байгалийн эрсдэлийн хүчин зүйл илрэхэд зүүн талын зурган дээр амь нас, эд хөрөнгө, орчны хохирол бий болсон тул энэ нь гамшиг, харин баруун зурган дээр цөлд газар хөдлөлт болсон хэдий ч ямар нэгэн аюул учраагүй тул гамшиг гэж хэлэхгүй.

Q. Дасгал ажил 4

Эрсдэлийн хүчин зүйлс болон гамшгийн ялгаа

Эрсдэлийн хүчин зүйлсийн төрлүүд

- Эрсдэлийн хүчин зүйлсийн төрлүүд
- Бороо их орсноос болж манай тосгоны голын үсний түвшин нэмэгдэж байна.
- Номхон далайд байдаг нэгэн хүнгүй арлыг цунами нөмөрлөө.
- Гангвондугийн уулын бэл дэх тосгонд их хэмжээний цас орлоо.
- Номхон далайд үүссэн далайн том шуурга манай улс руу ойртож байна.
- Цас их орсноос болж Чүнчон руу явдаг хурдны замыг хаав.

Гамшиг

- Шувууны ханиад дэгдэж 30,000 тахиаг устгалд оруулав.
- 40 хэмээс дээш аагим халуун болсноос ганцаараа амьдардаг 100 гаруй өндөр настан түргэн тусламжийн тасагт хүргэгдлээ.
- Гёнжу хотод газар хөдлөлт болж байшин нурснаар оршин суугчид түр орогнох байранд амьдарч байна.

Нөхөн сэргээгдэх чадвар


Эрсдэлийн хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх эсвэл аюулаас болж гамшиг нүүрлэх үед урьдчилан бэлтгэлтэй байснаар гамшгийн дараа буцаад хэвийн байдалдаа орох чадварыг хэлнэ.



Эрсдэлийн хүчин зүйлсээс үүдэлтэй гамшгийн хохирлоос бүрэн ангид байхыг хэлнэ.
Жишээ нь: Хөрсний нуралт үүсэх аюултай газраас оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх



Эрсдэлийн хүчин зүйлсээс үүсэж болзошгүй хохирлыг оновчтойгоор урьдчилан таамаглаж, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх явдал.
Жишээ нь: Эрт зарлан мэдээлэх системийг бий болгох, нүүлгэн шилжүүлэх сургууллт, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, яаралтай тусламжийн хэрэгсэл болон анхны тусламжийн хэрэгслээр хангах гэх мэт.



Эрсдэлийн хүчин зүйлсээс үүсэх хохирлын хэмжээг бүүрүүлэх
Жишээ нь: Далан барих (Хөрсний нуралтаас урьдчилан сэргийлж, хөрс доош урсаххаас урьдчилан сэргийлэх тохижилт), Борооны үс хуримтлуулах сан (бороо орсон үед хоолойд борооны усыг нөөцлөх явдал), Газар хөдлөлтөөс сэргийлэх байгууламж гэх мэт

Tilly Smith бичлэг

1. Хичээлийн зорилт

Сурагчдад гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт нь яагаад хэрэгцээтэй болохыг ухааруулах юм.

2. Багш болон сургалт

Үндсэн агуулга

Гамшгаас сэргийлэх аюулгүй байдлын сургалтын чухлыг бодит жишээн дээр тулгуурлан сурагчдад ойлгуулж, сурагчид энэхүү сургалтанд хамрагдсанаар гамшгийн үед эргэн тойрны хүмүүст тусламж үзүүлэгч нь болж чадахыг онцолж ойлгуулах.




Багшийн сургалтын хэрэглэгдэхүүн
(бэлтгэх зүйл)

Tilly бичлэг
<https://youtu.be/j95EyYln3Z8>



3. Ерөнхий агуулга



Тилли Смит нь бүхий л зүйлд сониуч, сэргэлэн 10 настай энгийн нэгэн англи охин билээ.

2004 оны 12 сарын 26-нд Номхон далайг бүхэлд нь нөмөрсөн цунамигаас болж Тайланд, Индонези зэрэг Азийн орнуудад 270,000 хүн амиа алдсан билээ.

Цунами болох үед Тилли охин гэр бүлийхэнтэйгээ хамт Тайландын Пүкет хотод амарч байжээ.

Пүкет хотын ихэнх газрууд цунамигаас их хохирол амссан ч Тиллигийн байсан далайн эрэг дээр Тилли яаралтай арга хэмжээ авсны ачаар 100 гаруй хүний амийг аварч чаджээ.

Ийм гэнэтийн аюул тулгарахад гэр бол болон эргэн тойрны хүмүүсийн амийг аварч чадсан нь 2 долоо хоногийн өмнө сургууль дээрээ газарзүйн хичээлд дээр цунами ирж буй дохио болон авах арга хэмжээний чухлыг багш нь зааж өгсөн байсны ач билээ.

“Эрсдэлийн арал тоглоом” (Riskland game)

1. Сургалтын зорилго

UNDRR, UNICEF хамтран 2002 онд зохиосон гамшгаас урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын сургалтанд зориулсан энэхүү тоглоом нь 20 гаруй орны хэл дээр орчуулагдан хэвлэгдэж, олон орны сургуулиуд сургалтандаа ашиглаж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулахыг хялбар сонирхолтойгоор ойлгож аван, хэлэлцүүлэг болон оролцоогоор дамжуулж гамшгаас урьдчилан сэргийлснээр хохирлын хэмжээг багасгах аргад суралцах боломжтой.

1. Багш болон сургалт

Хөлөгт тоглоомоор дамжуулан олон янзын эрсдэлийн хүчин зүйлсээс хэрхэн урьдчилан сэргийлэх, яаралтай арга хэмжээ авах, ямар үйлдлүүд нь гамшгаас үүсэх хохирлыг бууруулж болох мөн эмзэг байдалд хүргэх хүчин зүйлүүдийн талаар ойлголт өгнө.



Багшийн бэлдэх материал

Тоглоомын хөлөг, шоо 1ш, морь 4ш, асуултын карт 24ш, гэнэтийн карт 24ш



Асуултын карт: (шар шувуу)



Гэнэтийн карт: (сармагчин)

3. Ерөнхий агуулга





Анхаарах зүйл

- Тоглогчийн тоо** 4 хүн нэг баг болж тогловол тохиромжтой.
- Тоглоомын хугацаа** Үргэлжлэх хугацаа 30мин дотор.
- Тоглох арга**
1. Морио сонгоод дараа нь дарааллаа тогтоогоорой.
 2. Бүх морьдыг гараан дээр байрлуулна.
 3. Шоог ээлжлэн хаяж, буусан нүдний хэмжээгээр урагш нүүнэ.
 4. Зааварчилгаа бичигдсэн нүдэнд таарвал бичсэн зааврыг чангаар уншиж, зааврыг биелүүлнэ.
Жишээ нь : “Оршин сүүгчид мод их хэмжээгээр тайрсан. Гараа руу буцаж очино уу.
 → Шоог хаясан сурагч гараа руу морио буцаана.
 5. Асуултын нүдэнд очвол дараагийн хүн нь -ийг эргүүлээд картанд байгаа асуултыг чанга дуугаар асууна. Хэрвээ асуултанд зөв хариулж чадвал шоо дахиж нэг удаа шидэх эрхтэй болж, харин асуултанд хариулж чадахгүй бол дараагийн хүн тоглоомыг үргэлжлүүлнэ. Хэрэглэсэн картаа хамгийн доор нь оруулна.
Жишээ нь : Асуулт: Уулыг мод ихтэй байлгах нь яагаад чухал вэ?
Зөв хариулт : Байгалийг хамгаалж, хөрсний элэгдэлт, нуралтаас хамгаална, мөн гол горхийг хамгаалахын тулд.
 6. Гэнэтийн нүд таарвал шоог шидсэн хүн -ийг эргүүлээд карт дээрх зааварчилгааг чанга дуугаар уншиж, гүйцэтгэнэ.
Жишээ нь : Сургуулийн номын сангаас гамшгаас сэргийлэх материал хайж байгаад гол горхио хоггүй цэвэрхэн байлгах нь үер усны аюулаас урьдчилан сэргийлэх нэг арга гэдгийг мэдсэн. 5 нүд урагшилаа уу.
 7. Бариа (65дугаар нүд)-нд хамгийн түрүүнд яг оновчтойгоор очсон хүн ялагч болно.
Жишээ нь : 62 дахь нүдэнд байх үедээ шоо хаяхад 5 буусан бол урагш 3 нүд нүүж барианд очсоны дараа үлдсэн тооны хэмжээгээрээ буюу 2 нүд ухарч нүүнэ гэсэн үг.

- Болж өгвөл багш тоглоомонд бага оролцох. Харин сурагчид тоглож байх үедээ асуултын картанд байгаа асуултанд хариулж чадахгүй үед багш зөв хариултыг хэлж өгч туслаарай.
- Багш эхлээд картан дээр байгаа агуулгыг урьдчилан уншиж мэдсэн байх. Сурагчдын ойлгох чадварыг харгалзан үзэж хэцүү байх гэж бодсон картуудыг хасаж болно.
- Зааварчилгаа, асуулт, гэнэтийн картан дээрх агуулгыг сурагчид чанга дуугаар уншиж байгаа нь агуулгыг бусад сурагчдад сонсож хуваалцахад маш чухал үүрэгтэй юм.
- Тоглоом дууссаны дараа багш карт дээр байгаа агуулгыг сурагчдаас дахиж асуух

маягаар хичээлээ бататгаж өгвөл илүү сайн.

- Гараанд аль хэдийн хүрсэн сурагч байсан ч үлдсэн сурагчид гараанд бүгд хүрэх хүртэл тоглоомоо үргэлжлүүлж болно.

※ Энэ тоглоомын зорилго нь аль болох олон сурагчдад картан дээр бичигдсэн мэдээллийг хүргэх явдал юм.

Hazar bingo
ТОГЛОМ

1.Сургалтын зорилго

Хичээлийн цаг дээр сурсан гамшгийн хохирлыг бууруулахтай холбоотой ойлголтуудыг сурагч сэргээн санаж, бататгах дасгал болох боломжтой.

2.Багш болон сургалт

Гол агуулга


- Сургуулийн аюулгүй байдлын хөтөлбөрөөр сурсан мэдлэгээ ашиглан сурагчдаар өөрсдөөр нь бинго картыг бөглүүлнэ.
- Хичээлийн төгсгөлд тогловол хичээлээ бататгаж, давтахад илүү үр дүнтэй.



Багшийн хичээлийн хэрэглэгдэхүүн(бэлдэх зүйл)

Бинго карт (Хүн нэг бүрт эсвэл баг бүрт нэг нэг карт), бал цаас бэлдэх

2.Багш болон сургалт





Багшийн анхаарах зүйл

- Тоглогчийн тоо** Нэг нэгээрээ эсвэл 4 хүн нэг баг
- Тоглоомын хугацаа** 30 минут дотор
- Тоглох арга**
1. Сурагчдад бинго картыг тарааж өгч, бинго картыг бөглөх цаг өгнө.
※Сурагчдад тусламж хэрэгтэй бол 6-р хуудас дээр байгаа Дасгал ажил 1 гэсэн хэсгийг харуулаарай.
 2. Сурагчид хичээл дээрээ сурсан гамшгийн эрсдлийг бүүруулахтай холбоотой үг болон ойлголтоос 1 нүдэнд нэг үг бичиж бинго картыг бөглөнө.
 3. Картаа бүгдийг нь бөглөж дуусвал бинго тоглоомын дүрмийн дагуу тоглож эхэлнэ.
[4 мөр (16 нүд), 5 мөр (25 нүд)]

- Сурагчдаас хэрэв ойролцоо утгатай үг гарч ирвэл хүлээн зөвшөөрөх эсэхээ хэлж өгөөрэй.
- Жишээ нь: эрсдэлийн хүчин зүйл=эрсдэлийн элемент, хар салхи=хорикэйн=халуун орны салхи, аюул=эрсдэлийн хүчин зүйл
- Багш үг гарах бүрт тэр үгийг самбар дээр бичиж үг давхцуулахгүй байх.



Холбоо барих утас

- Хаяг** Инcheon хот, Ёнсү дүүрэг, Арт сэнтоотэру 175 G Tower 4 давхар
- Утас** 032-458-6559
- Вэб хуудас** www.UNDRR.org/incheon
- E-mail** sinh@un.org

United Nations Office
for Disaster Risk Reduction

